



НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Нийслэлийн инновацийн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгааны ажил хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны Ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Инновацийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 14 дүгээр зүйлийн 14.2, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/187 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг,нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Нийслэлийн инновацийн дэд хөтөлбөрийг боловсруулах талаар тусгагдсаны дагуу инновацийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд инновацийн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгааны ажлыг зохион байгуулсугай.

2.Дээрх судалгааг хийх талаар байгууллагуудаас ирүүлсэн үнийн саналуудад үндэслэн нийслэлийн инновацийн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийж гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний зардал болох 10.000.000,0 /арван сая/ төгрөгийг Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас гаргахыг Нягтлан бодогч /С.Мөнхдорж/-д зөвшөөрсүгэй.

3.Нийслэлийн инновацийн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгааны зөвлөх үйлчилгээг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, судалгааны дундын тайланг хэлэлцүүлж, эцсийн тайланг 2018 оны 06 дугаар сарын 15-ны дотор газрын хурлаар хэлэлцүүлэхийг Инновацийн хэлтэс /Ш.Ням/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ

D:My doc/tushaal/2018